

МОНГОЛЫН АНАГААХЫН БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦООНЫ
XVI-XVIII ЗУУНЫ ТҮҮХИЙН ЗАРИМ АСУУДЛЫГ
ТОДРУУЛАХ НЬ

Н.Зулцэцэг¹, Ш.Болд²

¹ЭЗШУИС, ²ШУА

SOME ISSUES OF THE HISTORY OF THE
MONGOLIAN MEDICAL EDUCATION SYSTEM BETWEEN
16TH AND 18TH CENTURIES

Zultsetseg N¹, Bold Sh²

¹Mongolian University of Pharmaceutical Sciences,

²Mongolian Academy of Sciences

ABSTRACT

By the beginning of the 20th century, more than 750 temples and monasteries were established and most of them had manba datsan (Medical school). For example, the names of the 104 major monasteries with mamba datsan were identified.

Traditional medicine personnel were systematically prepared and names of manba datsan and establishment date were identified, which is an important significance of the research.

According to our research, nearly all major monasteries have their own manba datsan, and the Ikh Khuree manba datsan Sorigshampanlin, Zayiin Khuree manba datsan, Tariatyn Khuree of Choinkhor Van, manba datsan of Lamyn Gegeen Khuree, manba datsan of Khand Chinvan Khuree were not only famous for their training but also talented doctors.

The basic condition for preparing doctors based on the “Four Medical Tantras” book is directly related to the third introduction of Buddhism in Mongolia in the 16th century. Datsans of various disciplines were established long with the large Buddhist monasteries in Mongolia, including manba datsan for educating doctors.

Key words: manba datsan, monasteries, traditional medicine, Buddhism

Үндэслэл XVI зуунаас Монгол оронд бурханы шашин 3 дахь удаагаа дэлгэрэхийг дагалдан сүм хийдийн дэргэд мэдлэг ухааны янз бүрийн салбарыг хамарсан дацангууд байгуулагдсаны дотор анагаах ухааны боловсрол олгож, эмч лам нарыг бэлтгэх сургууль мамба дацан байгуулагдаж эхэлжээ. Мамба дацан гэдэг нь одоогийнхоор бол анагаах ухааны сургууль гэсэн ойлголт юм.

Мамба дацан байгуулагдах үндсэн нөхцөл нь Монголд буддын шашин дэлгэрсэнтэй шууд холбоотой юм¹.

Монголын өргөн уудам нутгаар тархан суурьшиж байсан нүүдэлчин Монголчууд XV зууны эхнээс XVI зууны эцэс хүртэлх хугацаанд Төвөд, Хятад дахь буддын шашны төрөл бүрийн төв газруудтай ямар нэгэн харьцаатай байж, сүм хийдээр нь очиж, лам хуврагуудтай нь уулзан учирч байсан байна.

Монголын Түмэн Засагт хаан /1558-1593/ 1576 онд Төвөдийн Гарма хийдийн улаан малгайтны суртлын тэргүүн Илдунийг /Илдийг/ зангидагч Гарма ламыг өөрийн өргөөндөө залж, багш, шавийн

барилдлагатай болж, Зүүн зургаан түмний дотор улааны шашныг дэлгэрүүлж номын үүдийг нээв².

Баруун, Зүүн түмний Жинон буюу Түмэдийн Алтан хан /1507-1582/ 1573 оны үеэр 20 гаруй төвөд ламыг өөрийн нутагт залан ирүүлж хурал, номын үйлсийг үүсгэн явуулж байжээ. Үүний хамтад мянган мутарт, мянган нүүрт Хонсим Бодисатва буюу Жанрайсаг зэрэг бурхадын алтадсан хөргүүд болон алтан үсгийн “Алтангэрэл” зэрэг төвөд үсгийн хөлгөн судруудыг залж авчирсан байжээ. 1578 онд Алтан хан Төвөдийн шарын шашны тэргүүн Содномжамцтай өөрийн биеэр уулзан түүнд “Очир дара далай лам” цол олгож монголчуудын дунд шашныг дэлгэрүүлэх болсоноо албан ёсоор тунхаглав.

Түүнчлэн Халхын Автай сайн хаан /1554-1588/ 1581 оноос эхлэн III Далай лам Содномжамцтай харилцаа тогтоон 1586 онд Далай лам Содномжамц хоёр дахь удаагаа Түмэд нутагт хүрэлцэн ирэх үеэр өөрийн биеэр уулзан шарын шашинд оржээ³.

Зорилго

Бурханы шашин гурав дахь удаагаа дэлгэрсэн XVI-XVIII зууны үеийн Монголын анагаахын боловсролын тогтолцооны түүхийн зарим асуудлыг судлан тогтоох.

Судалгааны арга

- Герменевтик арга

Энэ үг нь тайлбарлах тодруулах гэсэн Грек үгнээс гаралтай бөгөөд сэдвийн өгүүлэмж, нэр томъёо, үгийн утгын тайлал хийх, тайлбарлах, орчуулахад хэрэглэдэг аргын нэр юм. Герменевтик нь судалж буй зүйлийнхээ учир зүйг учир шалтгааны холбоогоор тайлбарлан судалдаг, гол мөн чанар нь зохиогчийг өөрөөс нь илүү ойлгож болох буюу зохиогчийн ухамсарлаж бодоогүй гол зорилт болон далд нуугдмал утга санааг илрүүлж болох явдал юм⁴. Иймээс энэхүү арга нь судалж буй асуудлын далд утга, давхар санаа, агуулгыг

судлан тогтоох зэрэгт ашиглав.

- Анализ-синтезийн арга

Задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх арга. Анализ нь задлах, ялгаж салгах гэсэн утгатай бөгөөд судлаач сонгож авсан объект буюу үзэгдэл юмыг өөрийн сэтгэхүйгээр тодорхой бүрэлдэхүүн хэсгүүдэд ангилна. Ингэснээр тухайн объектын хийсвэрлэж болох үндсэн шинж чанарууд тодорхой бүрэлдэхүүн хэсгүүд дээр илүү тод илэрч гарна. Энэхүү аргаар мамба дацангийн үүсэл хөгжил талаар олж цуглуулсан материалыг задлан шинжилж, тоогоор илэрхийлэн судлав. Задлан шинжилж гарсан үр дүнг нэгтгэн дүгнэх замаар анализ-синтезийн аргыг ашиглалаа.

Судалгааны үр дүн

XVII зууны эхэн үеэс эхлэн монголын эмч, эрдэмтэд Энэтхэгийн Аюурведийн анагаах ухааны алдарт эмч Вагбатын бичсэн “Найман гишүүнтийн зүрхэн хураангуй” /1500-1600/, түүний тайлбар зохиол Чандранандан /VIII зуун/-ы бичсэн “Найман гишүүнтийн зүрхний тийн тайлбар үг, утгын сарны гэрэл” зохиолыг гол сууриа болгон Төвөдийн мэргэн эмч, их Ютог Ёндонгомбо /729-854/ анх эмхэтгэн найруулан улмаар бага Ютиг Ёндонгомбо /1138-1213/ дахин хянан, нэмэлт засвар хийн эмхэтгэсэн, “Рашааны шимийн найман гишүүнт нууц увдисын үндэс” буюу товчоор “Дөрвөн үндэс” зохиолыг монгол хэлээр орчуулан, ёгт нэр томъёо, утга агуулгыг дэлгэрүүлэн тайлбарлан, монгол оронд “Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийн сургуулийг бий болох нөхцлийг бүрдүүлж эхэлжээ⁵.

Өндөр гэгээн өөрийн өргөө болон түүний орчимд бурханы шашны хурал, мөргөлийн үйлдэл явуулах болж, улмаар харъяалсан шадар хэргэмтэн хүмүүс ба сан жасад тулгуурлан 1651 онд Сангийн, Зоогийн, Жасын, Дархан эмчийн гэх мэт 7 хэсэг байгуулж “7 аймаг” хэмээн нэрлэсэн байна.

Учир нь Өндөр гэгээний урилгаар ирж

дархан эмч цолтой болсон нэг төвөд эмч 1651 онд энэ аймгийг байгуулсан учир түүний нэрээр уг аймгийг нэрлэжээ.

Энэ үеэс эхлэн “Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийн урсгал маш хүчтэй дэлгэрэн ар, өвөр Монголд шарын шашны сүм, хийдийн дэргэд эмчийн сургуулиуд олноороо байгуулагдан “Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийг “Шүн” буюу гол сурах бичиг хэмээн дээдлэн, тахиж иш ухаан онол, дадлагынхаа үндсийг болгосоор иржээ. Монголын мамба дацангуудын уламжлал голцуу Амдогийн Гүнбүм хийдийн Соригшанпанлин Мамба дацангийн дэгийг дамжуулан авсан байдаг. Түүнчилэн Гүнбүмийн Мамба дацанд ч олон Монгол лам нар эмийн ухаанд боловсрон нутагтаа ирдэг байжээ. Ордосын Агваандамбийням гэдэг хүн XIX зууны үед тус дацангийн хамба болж байсан бол одоо Хөх Нуурын Монгол гаралтай Сэрдэг гэгээний хувилгаан дүр Гүнбүм Жамбаалин хийдийн мамба дацангийн хамбын сэнтийд заларч байгаа болно. Мамба дацангуудийн гол шүтээн нь мэдээж Оточ Бурхан бөгөөд ядам нь ихэвчлэн Доржпүрэв, сахиус нь Шанлон сахиус байдаг⁶.

Бидний хийсэн судалгаагаар бараг ихэнх томоохон хүрээ хийдүүд өөрийн мамба дацантай байсан бөгөөд Их Хүрээний мамба дацан Соригшампанлин, Заяын хүрээний мамба, Далай Чойнхор вангийн Тариатын хүрээ, Ламын гэгээний хүрээний мамба дацан, Ханд Чинвангийн хүрээний мамба дацан сургалт хийгээд эрдэм чадалтай эмч мэргэдээрээ алдартай байжээ. Эмчийн дацангууд нэрээрээ танигддаг бөгөөд Соригшанпанлин буюу Бусдад туслах анагаах ухааны орон, Сориггүнпанлин буюу Хотолд туслагч анагаах ухааны орон, Цэжүдлин буюу Насны шимийн хийд гэх мэт нэрээрээ ялгаран танигдаж байдаг.

Судлаач Н.Дашзэвэг бүтээлдээ: Монгол

оронд мамба дацан байгуулагдсан ба түүний зохион байгуулалт, үйл ажиллагааг Их Хүрээний мамба дацан, Ханддорж Чин вангийн хошууны мамба дацангуудын жишээн дээр тайлбарлан таниулсан нь нилээд ул үндэстэй, судалгааны чухал материал болжээ⁷. Ялангуяа Н.Дашзэвэг 1960-1972 он хүртэл Гандантэгчэлэн хийдийн маарамба М.Ядамсүрэн, Булган аймгийн маарамба Д.Чойжамц нараар “Анагаах ухааны дөрвөн үндэс”, “Лхантав” зэрэг номыг заалгаж, 1966 оны 8 дугаар сарын 9-ий өдөр маарамбын дамжаа ёслон барьсан байна. Ийм учраас мамба дацангийн сургалтын зах цухыг өөрийн биеэр үзсэн “ховор” хүмүүсийн нэг нь Н.Дашзэвэг агсан юм.

Түүхч Ч.Банзрагч, Б.Сайнхүү нарын эмхтгэсэн бүтээл нь XVI зууны үед үүссэн “Халхын Бат Эрдэнэ зуу”, XVII зууны эхний хагаст байгуулагдсан “Номын Их Хүрээ”, XVIII зуунд зарилгаар бүтээгдсэн “Амарбаясгалан”, “Шашныг бадруулагч” мэт томхон хүрээ хийдүүдээс эхлээд XIX-XX зууны хугацаанд хөдөө сум, отог, багт олны өглөг хандиваар босгосон их, бага хурал, дуган, сүмүүдийн түүх боломжийн хэрээр багтсан томоохон лавлах болжээ⁸. Энэ номонд зарим мамба дацангуудын байгуулагдсан хугацаа тодорхой тусгагдсан байна.

Академич Ш.Болдын 2005 онд туурвисан “Монголын уламжлалт анагаах ухааны хөгжлийг эх сурвалжийн судалгаагаар тодруулах нь” нэг сэдэвт бүтээлд Монгол даяар алдартай томоохон хүрээ, хийдийн дэргэд мамба дацангууд байгуулагдсаар XX зууны эхэн гэхэд 750 гаруй сүм, хийд бий болж ихэнх нь мамба дацантай болсныг тодруулан, мамба дацантай нийт 104 томоохон сүм хийдийн нэрийг тодруулан гаргажээ⁹. Ингэж уламжлалт анагаах ухааны боловсон хүчнийг тогтолцоотойгоор бэлтгэж байсан нь судалгаагаар олж тогтоосон мамба дацангийн

нэр, байгуулагдсан он цагийг тодруулсан нь судалгааны чухал ач холбогдолтой болжээ. Мөн Их Хүрээнд эмчийн зэрэг цол олгох, чимэг, шагнал өгөх, өрхийн эмчийн хэлбэрээр ажиллаж байсан хэсүүлийн эмчийн талаар архивын материалд үндэслэн шинээр гарган тавьсан байна¹⁰.

Дүгнэлт

“Анагаах ухааны дөрвөн үндэс” номонд суурилсан эмч бэлтгэх үндсэн нөхцөл нь XVI зуунаас Монгол оронд бурханы шашин 3 дахь удаагаа дэлгэрэхтэй шууд холбоотой юм. Монголд байгуулагдсан бурханы шашны томоохон сүм хийдийн дэргэд мэдлэг ухааны олон янзын салбарыг хамарсан дацангууд байгуулагдсаны дотор эмч бэлтгэх мамба дацан чухал байр эзэлж байжээ.

Ном зүй

1. Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны түүх. УБ, 2006
2. Бира Ш. Монголын түүх соёл, түүх бичлэгийн судалгаа. Токио, 1994
3. Бира Ш. Монголын түүх соёл, түүх бичлэгийн судалгаа. Токио, 1994
4. Ганхуяг Ш, Гантуяа М. Философийн түүхэн тойм. УБ, 2002, х. 358
5. Болд Ш. “Монголын уламжлалт анагаах ухааны хөгжлийг эх сурвалжийн судалгаагаар тодруулах нь” АШУ-ны докторын зэрэг хамгаалсан нэг сэдэвт бүтээл. УБ, 1998
6. Цэцэгдарь Т. XIX-XX зууны эхэн хүртэлх Монголын зарим мамба дацангийн зохион байгуулалт сургалтын онцлогийг тодруулах нь. Магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. УБ, 2017
7. Дашзэвэг Н. Монголын анагаах ухааны товч түүх. УБ, 1998
8. Банзрагч Ч, Сайнхүү Б. Монголын хүрээ хийдийн түүх. УБ, 2004
9. Болд Ш. “Монголын уламжлалт анагаах ухааны хөгжлийг эх сурвалжийн

судалгаагаар тодруулах нь” АШУ-ны докторын зэрэг хамгаалсан нэг сэдэвт бүтээл. УБ, 1998

10. Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны түүх. УБ, 2006

*Уншин танилцаж,
нийтлэх санал өгсөн:
Академич, ЭЗУ-ы доктор, профессор
Л.Хүрэлбаатар*